



ДУНДГОВЬ АЙМАГ
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 12 өдөр

Дугаар А/123

Хажуу шинэ үс

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 214 дүгээр захирамжийг хэрэгжүүлэх зорилгоор, Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын даргын 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/109 тоот тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хууль тогтоомжийн хүрээнд судлан үзэж, шуурхай шийдвэрлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Н.Өлзийтогтох (Тамгын газрын дарга)

Нарийн бичиг: Э.Лайжинханд (Архив, бичиг хэргийн эрхлэгч)

Гишүүн: Л.Батбаатар (1 дүгээр багийн Засаг дарга)

2. "Хэрэглэгчийн мэдээллийн 115 төв"-д ажиллах албан хаагчдын хуваарийг гаргаж, удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Өлзийтогтох)-д үүрэг болгосугай.

3. Иргэдээс ирсэн өргөдөл гомдолд тусгагдсан асуудлыг өөрийн эрхлэх асуудлын хүрээнд шийдвэрлэх, зөвлөгөө мэдээлэл өгч, шуурхай хариу хүргүүлэн ажиллах, шийдвэрлэлтийн мэдээг тухайн өдрийн 17:00 цагаар тасалбар болгон и мэйл, утсаар маягтын дагуу гарган ажлын хэсэгт хүргүүлж, байгууллагын нийт албан хаагчдыг шаардлагатай тохиолдолд холбоо барих нөхцөлийг бүрдүүлж, зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллахыг ажлын хэсгийн нарийн бичиг (Э.Лайжинханд)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ө. МӨНХ-АМГАЛАН

482201123